



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 1122

Хэрлэн сум

Байгууллагын ахмадад хүндэтгэл
үзүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам"-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэрлэн сумын 4 дүгээр багийн Ахмадын зөвлөлөөс санаачлан сар бүр хуваарийн дагуу тус багийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх "Сар бүрийн 15" хүндэтгэлийн өдөрлөгөөр байгууллагын ахмад Д.Пүлжиннямыг алдаршуулах зардалд 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг байгууллагын ахмадын сангаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн
122 дугаар тушаалын хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

| № | Зардлын төрөл | Нэгжийн үнэ | Тоо, хэмжээ | Нийт үнэ |
|---|--|-------------|----------------|----------|
| 1 | Байгууллагын ахмад настан Д.Пүлжиннямыг алдаршуулж, хүндэтгэл үзүүлэх зардал | 550,000 | 1 | 550,000 |
| | Нийт | | | 550,000 |